ЦӨЛЖИЛТИЙН СУДАЛГААГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Цөлжилтийн судалгаа хийлгүүлэх ажлын зорилго: Аймгийн хэмжээнд нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан цөлжилт, газрын доройтлын судалгааг гүйцэтгүүлж, үнэлэлт, дүгнэлт гаргаснаар цөлжилтийг сааруулах, уур амьсгалыг зөөлрүүлэх, газрын доройтлыг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болох зорилготой.

"Цөлжилтийн судалгаа, түүнд үндэслэн Баянхонгор аймгийн цөлжилтийг сааруулах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулах ажлын хамрах хүрээ, агуулга үе шатууд	"Цөлжилтийн судалгаа, түүнд үндэслэн Баянхонгор аймгийн цөлжилтийг сааруулах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулах ажлыг аймгийн хэмжээнд цөлжилт ихээр явагдсан, цөлжилтийн нөлөөнд дунд зэрэг өртсөн газруудад хийж гүйцэтгэнэ. Судалгааны ажил нь • Бэлтгэл ажил • Хээрийн судалгааны ажил Тайлан боловсруулж, хүлээгэн өгөх гэсэн 3 үе шаттайгаар явагдана.
БЭЛТГЭЛ АЖИЛ	Бэлтгэл ажлын хүрээнд: • Судалгааны маршрут гаргах • Судалгаанд шаардлагатай багаж хэрэгсэл бэлтгэх • Сумдын холбогдох /хөдөө аж ахуйн тасаг, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч/ мэргэжилтнүүдийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулна.
ЦӨЛЖИЛТИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ	• Аймаг болон сум тус бүрээр цөлжилтийн төлөв, газрын доройтлын байдлын үнэлгээг өгч, зэрэглэн М1:200000 масштаб бүхий зураглал үйлдэх; • Цөлжилт, газрын доройтлын байгалийн болон хүний нөлөөллийн шалтгаан, хүчин зүйлүүдийг тогтоон үнэлэх; • Уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдалд өнгөрсөн, одоо цаашид гэсэн 3 үечлэлээр үнэлгээ өгөх; • Хээрийн судалгаа явуулж ургамалжилтын болон хөрсний голлох хэв шинжийн өөрчлөлтийг тодорхойлох, лабораторийн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгөх; • Аймаг сумын хэмжээнийн цөлжилт, газрын доройтлын байгалийн хүчин зүйлийг тооцон үнэлж, тодорхойлон гаргах; • Цөлжилт, газрын доройтол үүсч буй хүний хүчин зүйлийн шалтгаан, нөхцлийг тодорхойлон гаргах; • Цөлжилт, газрын доройтлын нийгэм-эдийн засагт нөлөөлж буй хүчин зүйлийг үнэлэх; • Баянхонгор аймгийн аймгийн уур амьсгалын (хур тунадасны өөрчлөлт, агаарын температурын өөрчлөлт, хуурайшил,

	чийгшлийн) өөрчлөлтөнд үнэлгээ дүгнэлт өгөх; • Цөлжилт, газрын доройтлын судалгаанд үндэслэн "Баянхонгор аймгийн цөлжилтийг сааруулах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулан хүлээлгэн өгөх; • Хээрийн судалгааны үр дүнд нийтдээ 270-300-аад хөрс, ургамлын дээж материалд лабораторийн шинжилгээ хийх цөлжилтийг илэрхийлэгч ургамлын төрөл зүйл, хөрсний нягт, сүвшилт, бүхэлшилт зэргээр цөлжилт, газрын доройтлыг үнэлэх Ургамлан нөмрөг, төрөл зүйлийн өөрчлөлт, хөрсний хими-физикийн шинж чанарын өөрчлөлт г.м үнэлэх; • Цөлжилтийг илэрхийлэгч ургамлын төрөл зүйл хөрсний нягт, сүвшилт, бүхэлшилт зэргээр цөлжилт, газрын доройтлыг үнэлэх; • Судалгаанд хамрагдаж буй аймгийн хэмжээнд болон орон нутгийн иргэдийн цөлжилтийг сааруулах чиглэлээр хийж гүйцэтгэж буй технологи, арга туршлагуудыг олон улсын аргачлалын дагуу бүртгэж мэдээллийн санд оруулах; • Цөлжилтийн судалгаагаар хийгдсэн ажлын тайлан, зураглал, дата мэдээлэл, shape file, холбогдох судалгааны материалуудыг цахим хэлбэрээр CD-нд хуулж хүлээлгэж өгөх • Судалгааны ажлын тайланг тухайн байгууллагын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн протокол, албан бичгээр ирүүлэхдээ хувийг холбогдох яаманд хүргүүлэх • Захиалагчид хүлээлгэн өгөх судалгааны ажлын тайлан болоод авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний эх материал гүйцэтгэгч байгууллагад үлдэх эх материалтай тохирч байх

ХЯНАСАН
БАЙГАЛЬ ОРЧИН, ӨЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ГАНЗОРИГ

БОЛОВСРУУЛСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.ХАНДСҮРЭН